

# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Талын илч ОНӨААТҮГ-ын 2024 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГСА-2025/001/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Говьсүмбэр аймаг 2025 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: <a href="mailto:sarantuyab@audit.gov.mn">sarantuyab@audit.gov.mn</a> Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: <a href="mailto:naranbayarg@audit.gov.mn">naranbayarg@audit.gov.mn</a> Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Платиниум прогресс аудит” ХХК Захирал: Ж.Баяртуул Утас: 99066015, Цахим хаяг: <a href="mailto:platinumprogressaudit@gmail.com">platinumprogressaudit@gmail.com</a> Аудитор: Б.Дэлгэрмаа Утас: 90109012, Цахим хаяг: <a href="mailto:platinumprogressaudit@gmail.com">platinumprogressaudit@gmail.com</a></p>
-------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл .....
- 4.2 Материаллаг байдал .....
- 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ҮӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр гол, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-3064 3139  
E-mail: govsubambaudit.gov.mn

*2025.02.17* № *10*  
Төрийн \_\_\_\_\_ -ийн № \_\_\_\_\_ -т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
"ТАЛЫН ИЛЧ" ОНБААТУГ-ЫН  
ЗАХИРАЛ А.БАТЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн "Талын илч" ОНБААТУГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн орлого, үр дүн, цэвэр хөрөнгө/эмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн "Талын илч" ОНБААТУГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангалын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толиглуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын даад байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудитормын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудитормын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүтж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ан холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толиглуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа балтгахдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шварадлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцрэхтэй, зохистой гэж үзлээ.

422502037

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 67 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.0 хувийн гүйцэтгэлтэй гэх тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний бичлэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

## **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нэгтгэн бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайланг олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэх болжлуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залулан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залулан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөжөж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрнийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залулан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****/төгрөгөөр/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,906,812.29	751,196.61
Дансны авлага	41,522,401.99	19,028,950.66
Татвар, НДШ-ийн авлага	1,400.10	-
Бусад авлага	721,280.00	-
Бараа материал	61,444,833.47	68,113,642.99
Эргэлтийн хөрөнгийн дүн	106,596,727.85	87,893,790.26
Үндсэн хөрөнгө	1,375,294,804.61	1,400,203,468.23
Биет бус хөрөнгө	54,380,166.64	60,552,787.84
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,429,674,971.25	1,460,756,256.07
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,536,271,699.10</b>	<b>1,548,650,046.33</b>
Дансны өглөг	5,684,353.20	48,147,796.00
Татварын өр	3,940,875.08	31,814,553.06
НДШ - ийн өглөг	-	18,718,946.06
Бусад богино хугацаат өр төлбөр	-	117,000.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,625,228.28	98,798,295.12
Бусад урт хугацаат өр төлбөр	370,646,533.85	295,646,533.85
Урт хугацаат өр төлбөрийн дүн	370,646,533.85	295,646,533.85
Өр төлбөрийн нийт дүн	380,271,762.13	394,444,828.97
Өмч: - төрийн	1,572,400,240.20	1,572,400,240.20
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	86,304,329.64	86,304,329.64
Хуримтлагдсан ашиг	(502,704,632.87)	(504,499,352.48)
Тайлангийн үеийн ашиг	-	3,174,075.26
Өмнөх үеийн ашиг	(502,704,632.87)	(507,673,427.74)
Эздийн өмчийн дүн	1,155,999,936.97	1,154,205,217.36
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,536,271,699.10</b>	<b>1,548,650,046.33</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан****/төгрөгөөр/**

№	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	528,616,818.92	540,305,874.93
2	Борлуулалтын өртөг	421,050,926.20	523,862,735.29
3	Нийт ашиг( алдагдал)	107,565,892.72	16,443,139.64
4	Бусад орлого	130,853,526.00	180,089,764.34
5	Орлогын дүн	130,853,526.00	180,089,764.34
6	Борлуулалт, маркетингийн зардал	27,147,611.49	27,960,679.33
7	Ерөнхий ба удирдлагын зардал	162,796,009.79	165,040,220.00
8	Бусад зардал	11,917,478.13	-
9	Зардлын дүн	201,861,099.41	193,000,899.33
10	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(3,999,999.96)	-

11	Олз, гарзын дүн	(3,999,999.96)	-
12	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	32,558,319.35	3,532,004.65
13	Орлогын татварын зардал	3,259,242.09	357,929.39
14	Татварын дараах ашиг (алдагдал)	29,299,077.26	3,174,075.26
15	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	29,299,077.26	3,174,075.26

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,572,400,240.20	86,304,329.64	(532,360,618.92)	1,126,343,950.92
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	356,908.79	356,908.79
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	29,299,077.26	29,299,077.26
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
9	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,572,400,240.20	86,304,329.64	(502,704,632.87)	1,155,999,936.97
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(4,968,794.87)	(4,968,794.87)
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	3,174,075.26	3,174,075.26
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	1,572,400,240.20	86,304,329.64	(504,499,352.48)	1,154,205,217.36

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**
**/төгрөгөөр/**

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Мөнгөн орлогын дүн (+)	566,986,405.94	538,248,616.25
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	546,896,248.33	523,251,409.32
Татаас, санхүүжилтийн орлого	-	5,031,431.00
Бусад мөнгөн орлого	20,090,157.61	9,965,775.93
Мөнгөн зарлагын дүн (-)	546,707,710.14	540,404,231.93
Ажиллагчдад төлсөн	216,387,947.54	268,543,470.75
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	40,264,357.43	45,552,139.67
Бараа материал худалдан авахад төлсөн	60,355,102.00	51,448,466.13
Ашиглалтын зардалд төлсөн	36,357,871.01	31,966,930.25
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	82,064,574.00	80,405,565.63
Татварын байгууллагад төлсөн	54,875,846.91	35,977,551.08
Даатгалын төлбөрт төлсөн	38,229,484.19	18,066,355.92
Бусад мөнгөн зарлага	18,172,527.06	8,443,752.50
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	20,278,695.80	(2,155,615.68)
Мөнгөн зарлагын дүн (-)	44,900,000.00	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	44,900,000.00	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(44,900,000.00)	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(24,621,304.20)	(2,155,615.68)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,091,175.41	2,906,812.29
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,906,812.29	751,196.61

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**
**/төгрөгөөр/**

№	Орлого, зардлын нэр төрөл	Нийт дүн		Хэтрэлт, хэмнэлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Цалин	316,749,000.00	333,454,230.99	16,705,230.99
2	НДШ, ЭМД	45,928,605.00	43,711,045.01	-2,217,559.99
3	Гэрээт олговор	3,500,000.00	-	-3,500,000.00
4	Тэтгэвэрт гарах ажилтны тэтгэмж	24,640,000.00	-	-24,640,000.00
5	Материалын зардал	60,110,000.00	39,587,293.86	-20,522,706.14
6	Нүүрсний зарцуулалт	67,760,000.00	62,452,937.24	-5,307,062.76
7	Хөдөлмөр хамгаалал	3,500,000.00	5,297,702.47	1,797,702.47
8	Бичиг хэрийн зардал	2,050,000.00	2,242,497.11	192,497.11
9	Цахилгааны зардал	26,530,000.00	28,389,765.68	1,859,765.68

10	Гэрээт ажлын төлбөр	2,090,000.00	120,000.00	-1,970,000.00
11	Томилолтын зардал	3,400,000.00	-	-3,400,000.00
12	Шатахууны зардал	36,000,000.00	32,190,538.50	-3,809,461.50
13	Газрын төлбөр	280,000.00	248,220.00	-31,780.00
14	АТӨЯХТатвар	352,600.00	370,564.00	17,964.00
15	ҮХХТатвар	1,158,429.44	1,158,429.44	-
16	Агаарын бохирдол, ус бохирдуулсны төлбөр	30,000.00	922,468.50	892,468.50
17	Зам ашиглалтын татвар	81,000.00	41,000.00	-40,000.00
18	Тээврийн хэрэгслийн оношилгоо	112,545.45	50,000.00	-62,545.45
19	Зохицуулах үйлчилгээ	3,850,000.00	5,528,600.00	1,678,600.00
20	Элэгдлийн зардал	128,870,000.00	113,588,755.79	-15,281,244.21
21	Шинжилгээний зардал	327,600.00	79,000.00	-248,600.00
22	Даатгал	2,065,650.00	1,946,400.00	-119,250.00
23	Хогны төлбөр	600,000.00	600,000.00	-
24	Ажилчдын нийгмийн зардал:	3,500,000.00	5,460,000.00	1,960,000.00
25	Дулааны зардал	31,812,000.00	31,812,000.00	-
26	Шуудан холбооны зардал	3,742,300.00	3,331,186.61	-411,113.39
27	Тээврийн зардал	250,000.00	-	-250,000.00
28	Ахмадын зардал	1,000,000.00	1,544,103.64	544,103.64
29	Засвар үйлчилгээний зардал	500,000.00	214,954.55	-285,045.45
30	Аудитын төлбөр	1,960,000.00	-	-1,960,000.00
31	Гишүүнчлэлийн татвар	1,500,000.00	1,500,000.00	-
32	Байгууллага хөгжүүлэлтийн зардал	250,000.00	137,536.37	-112,463.63
33	Сургалтын зардал	800,000.00	200,000.00	-600,000.00
35	Банкны үйлчилгээний зардал	260,000.00	140,677.59	-119,322.41
36	Бусад зардал	520,000.00	543,727.27	23,727.27
38	Орлогын албан татварын зардал	1,325,251.00	-	-1,325,251.00
	<b>ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>777,404,980.89</b>	<b>716,863,634.62</b>	<b>-60,541,346.27</b>
	Дулааны орлого	574,151,200.00	484,646,058.99	-89,505,141.01

	Цэвэр бохир усны орлого	14,681,040.00	39,110,266.36	24,429,226.36
	Бусад орлого		16,539,549.58	16,539,549.58
	Үндсэн хөрөнгө орлогод авсан орлого	200,000,000.00	180,089,754.34	-19,910,245.66
	Нийт орлогын дүн	788,832,240.00	720,385,629.27	-68,446,610.73
	НИЙТ АШИГ АЛДАГДАЛ	11,427,259.11	3,532,004.65	-7,895,254.46

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулах алдаа илрээгүй.

Аудитаар нийт 1 зөрчил<sup>1</sup> илэрч зөвлөмж өгсөн.

#### 3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 3.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

#### 3.3 Зөвлөмж

1. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус газрын 2024 оны жилийн эцсийн байдлаар авлага өмнөх оноос 22.5 сая төгрөгөөр буурч, богино хугацаат өглөг өмнөх оноос 89.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Энэ нь 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.*

Өгсөн зөвлөмж: Богино хугацаат өглөгийг бууруулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийг төлөвлөгөөг хуулийн хугацаанд тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			